

XX ЗУУНЫ 70-90 ОНЫ БНМАУ-ЫН ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАН ДАХЬ ТАНГАРАГЫН БУС ХАРИЛЦАА

Д.Сүхбаатар. Монгол улсын их сургууль. Түүхийн тэнхим
Ө.Тайван. Өвөр Монголын их сургууль. Монгол судлалын төв

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд 1970-1990 он хүртэлх БНМАУ-ын хугацаат цэргийн албан дахь тангарагийн бус харилцаа буюу “дэглэлт”-ийг нарийвчлан судлах саналыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: тангараг, цэргийн албан хаагч, тангарагын бус харилцаа, оны ялгаа, дэглэлт

XX зууны Монголын түүхийн нэгэн чухал судлагдахуун болох цэрэг армийн түүх нь судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг. БНМАУ-ын батлан хамгаалах хүчин чадал хэдийгээр улс төр, ёс суртахууны хараат байдалд байсан боловч түүнийг эдүгээ болтол нэгэн сэдэвт болгон судалсан судалгаанууд нь хэт нэг талыг барьсан, батлан хамгаалах хүчин чадлыг магтан дуулсан, статистик тоон үзүүлэлтээр тодорхойлж бичиж байжээ.

Бидний судалгааны сэдэвт хамрагдах хүрээнд мөрдөгдөж байсан цэргийн тангарагууд нь тухайн үеийн нийгмийн харилцаанд зохицсон цэрэг эх оронч сэтгэлгээнд тулгуурлаж байсан. Социалист бүтээн байгуулалтад үнэнч ЗХУ-д 1970-1990 ондуудад өргөж байсан цэргийн тангарагийн үзэл санаа нь БНМАУ-ын цэргийн тангарагт нөлөөлж тусгалаа олсон.

Нийгмийн харилцааны өөрчлөлтөөр цэргийн үе үеийн тангарагууд нь эх орон тусгаар тогтнолоо хамгаалах үзэл санаанаас гадна аажмаар тангарагийн бус харилцаанд шилжих үндэс суурийг тавьж өгсөн. Тухайлбал, үүнийг Оросын тангарагын өөрчлөлтөөс харж болно.

1. Военная присяга Русской Императорской армии (до 1917 года)

Обещаюсь и клянусь Всемогущим Богом, перед Святым Его Евангелием в том, что хочу и должен Его Императорскому Величеству Самодержцу Всероссийскому и Его Императорского Величества Всероссийского Престола Наследнику верно и нелицемерно служить, не щадя живота своего, до последней капли крови и все к Высокому Его Императорского Величества Самодержавству силе и власти принадлежащие права и преимущества, узаконенные и впредь узаконяемые, по крайнему разумению, силе и возможности исполнять.

Его Императорского Величества государства и земель Его врагов телом и кровью, в поле и крепостях, водою и сухим путем, в баталиях, партиях, осадах и штурмах и в прочих воинских случаях храброе и сильное чинить сопротивление и во всем стараться споспешествовать, что к Его Императорского Величества службе и пользе государственной во всяких случаях касаться может.

Об ущербе же Его Императорского Величества интереса, вреда и убытке, как скоро о том уведая, не только благовременно объявлять, но и всякими мерами отвращать и не допускать потщуся и всякую вверенную тайность крепко хранить буду, а предпоставленным надо мною начальником во всем, что к пользе и службе государства касаться будет, надлежащим образом чинить послушание и все по совести своей исправлять и для своей корысти, свойства и дружбы и вражды против службы и присяги не поступать, от команды и знамени, где принадлежу, хотя в поле, обозе или гарнизоне, никогда не отлучаться, но за оным, пока жив, следовать буду и во всем так себя вести и поступать как честному, верному, послушному, храброму и расторопному офицеру (солдату), надлежит. В чем да поможет мне Господь Бог Всемогущий.

В заключение сей клятвы целую слова и крест Спасителя моего. Аминь.

Оросын эзэнт гүрний цэргийн тангараг /1917 он хүртэлх/

Бүхнийг чадагч Агуу бурхан, ариун Евангелийн өмнө Оросын эзэн дээдэс, оросын залгамжлагч эзэн хаандаа амь нас, дусал цусаа үл хайрлан үнэнч шударга, хоёргүй сэтгэлээр зүтгэхээ амлан тангараглая.

Эзэнт хааны төр улс ба газар нутагт халдах дайснаас амь бие цусаа үл хайрлан хээр тал, хэрэм цайз, хуурай газар, ус, нам, отолт, дайралт болон бусад аливаа тохиолдолд эрэлхэг, хүчирхэгээр эсэргүүцэл үзүүлж, эзэн хаан, төрийн албандаа ашиг тустай байна.

Эзэн хаанд хор хөнөөлтэй аливаа зүйлийг мэдвэл нэн даруй мэдэгдэж, төрийн алба, ашигтай холбоотой дарга нарын даалгасан нууцыг чандлан хадгалж, дуулгавартай, тангарагтаа үнэнч байж, хаана ч байсан үнэнч, шударга, эр зоригтой байхаа тангараглая. Агуу бурхан надад туслаг. Аврагч бурханы загалмайт үнсэе. Аминь

2. Военная присяга 1918 года (Красная Армия)

Формула торжественного обещания, утвержденная в заседании Всероссийского Центрального Исполнительного Комитета Советов Рабочих, Солдатских, Крестьянских и Казачьих Депутатов от 22-го апреля 1918 года

1. Я, сын трудового народа, гражданин Советской Республики, принимаю на себя звание воина рабочей и крестьянской армии. 2. Пред лицом трудящихся классов России и всего мира я обязуюсь носить это звание с честью, добросовестно изучать военное дело и, как зеницу ока, охранять народное и военное имущество от порчи и расхищения. 3. Я обязуюсь строго и неуклонно соблюдать революционную дисциплину и беспрекословно выполнять все приказы командиров, поставленных властью Рабочего и Крестьянского Правительства. 4. Я обязуюсь воздерживаться сам и удерживать товарищей от всяких поступков, порочащих и унижающих достоинство гражданина Советской Республики, и все свои действия и мысли направлять к великой цели освобождения всех трудящихся. 5. Я обязуюсь по первому зову Рабочего и Крестьянского Правительства выступить на защиту Советской Республики от всяких опасностей и покушений со стороны всех ее врагов, и в борьбе за Российскую Советскую Республику, за дело социализма и братство народов не щадить ни своих сил, ни самой жизни. 6. Если по злему умыслу отступлю от этого моего торжественного обещания, то да будет моим уделом всеобщее презрение и да покарает меня суровая рука революционного закона.

Председатель ЦИК Я. Свердлов.

Секретарь ЦИК В. Аванесов 25" апреля 1918 года

Оросын улаан армийн цэргийн тангараг /1918/

Хөдөлмөрчин ард түмний хүү, Зөвлөлт улсын иргэн Би ажилчин тариачны армийн байлдагч болохоо хүлээн авч байна.

Оросын болон бүх дэлхийн хөдөлмөрчин ангийн нэрийн өмнө энэхүү нэрээ нэр төртэй авч явж, цэргийн хэрэгт шамдан суралцаж, ард түмний болон цэргийн эд хогшлыг шамшигдуулан эвдэхээс нүдний цөцгийн мэт хамгаалахаа тангараглая.

Би хувьсгалт сахилга батыг хатуу сахиж, ажилчин тариачны Засгийн газраас дэвшүүлсэн дарга нарын тушаалыг хэлбэрэлтгүй биелүүлэхээ тангараглая.

Би Зөвлөлт улсын иргэний нэр төрийг гутаах нөхдийнхөө болон өөрийнхөө аливаа үйлдлийг таслан зогсоох болон бүх хөдөлмөрчдийг чөлөөлөх агуу зорилгод өөрийн үйлдэл оюун санаагаа чиглүүлэхээ тангараглая.

Хэрэв би өөрийнхөө энэхүү ёслол төгөлдөр тангарагаасаа няцвал бүгдэд жигшигдэн, хувьсгалт хуулийн дагуу шийтгүүлнэ.

Би ажилчин тариачны засгийн газрын эхний дуудлагаар аливаа дайсны халдлага аюул заналхийллээс Зөвлөлт улсаа хамгаалах, Зөвлөлт болон социализмын үйл хэрэг, ард түмнүүдийн найрамдлын төлөө хүч чадал, амь насаа зориулахаа тангараглая.

Төв хорооны дарга Я. Свердлов
Төв хорооны нарийн бичгийн дарга В. Аванесов
4 сарын 25 өдөр 1918 года

3. Военная присяга Красной Армии (1939-47 гг)

Я, гражданин Союза Советских Социалистических Республик, вступая в ряды Рабоче-Крестьянской Красной Армии, принимаю присягу и торжественно клянусь быть честным, храбрым, дисциплинированным, бдительным бойцом, строго хранить военную и государственную тайну, беспрекословно выполнять все воинские уставы и приказы командиров, комиссаров и начальников.

Я клянусь добросовестно изучать военное дело, всемерно беречь военное и народное имущество и до последнего дыхания быть преданным своему народу, своей Советской Родине и Рабоче-Крестьянскому Правительству.

Я всегда готов по приказу Рабоче-Крестьянского Правительства выступить на защиту моей Родины — Союза Советских Социалистических Республик и, как воин Рабоче-Крестьянской Красной Армии, я клянусь защищать ее мужественно, умело, с достоинством и честью, не щадя своей крови и самой жизни для достижения полной победы над врагами.

Если же по злему умыслу я нарушу эту мою торжественную присягу, то пусть меня постигнет суровая кара советского закона, всеобщая ненависть и презрение трудящихся.

Оросын улаан армийн цэргийн тангараг /1939-1947 он/

Зөвлөлт социалист бүгд найрамдах улсын иргэн би ажилчин тариачны улаан армийн эгнээнд элсэн орохдоо үнэнч, эр зоригтой, сахилга баттай, сонор соргог байлдагч байж, цэргийн болон улсын нууцыг чанд хадгалж, цэргийн дарга, захирагч, комиссарын тушаал зарлигийг биелүүлэхээ ёслол төгөлдөр тангараглая.

Би цэргийн эрдэмд шамдан суралцаж, цэргийн болон ард түмний эд хогшлыг бүх талаар хайрлаж, эцсийн амьсгалаа дуустал ард түмэн, өөрийн эх орон, ажилчин тариачны засгийн газарт үнэнч байхаа тангараглая.

Би ажилчин тариачны засгийн газрын тушаалаар ажилчин тариачны улаан армийн байлдагч болохынхоо хувьд Зөвлөлт социалист бүгд найрамдах улс буюу өөрийн эх орноо амь нас, дусал цусаа үл хайрлан дайсныг бүрэн ялахын төлөө эр зоригтой, чадварлаг, нэр төртэйгээр хамгаалахаа тангараглая.

Хэрэв би энэхүү тангарагаасаа няцвал зөвлөлтийн хууль намайг хатуу шийтгэж, хөдөлмөрчид олон түмэнд жигшигдэх болно.

4. Военная присяга Советской Армии (до 1991 года)

Я, гражданин Союза Советских Социалистических Республик, вступая в ряды Вооруженных Сил, принимаю присягу и торжественно клянусь быть честным, храбрым, дисциплинированным воином, строго хранить военную и государственную тайну, беспрекословно выполнять все воинские уставы и приказы командиров и начальников.

Я клянусь добросовестно изучать военное дело, всемерно беречь военное и народное имущество и до последнего дыхания быть преданным своему Народу, своей Советской Родине и Советскому Правительству.

Я всегда готов по приказу Советского Правительства выступить на защиту моей Родины - Союза Советских Социалистических республик, и, как воин Вооруженных Сил, я клянусь защищать ее мужественно, умело, с достоинством и честью, не щадя своей крови и самой жизни для достижения полной победы над врагами.

Если же я нарушу эту мою торжественную присягу, то путь меня постигнет суровая кара советского закона, всеобщая ненависть и презрение трудящихся.

ЗХУ-ын армийн цэргийн тангараг /1991 он хүртэлх/

Зөвлөлт социалист бүгд найрамдах улсын иргэн би зэвсэгт хүчний эгнээнд элсэн орохдоо үнэнч, эр зоригтой, сахилга баттай байлдагч байж, цэргийн болон улсын нууцыг чанд хадгалж, цэргийн дарга, захирагч, комиссарын тушаал зарлигийг биелүүлэхээ ёслол төгөлдөр тангараглая.

Би цэргийн эрдэмд шамдан суралцаж, цэргийн болон ард түмний эд хогшлыг бүх талаар хайрлаж, эцсийн амьсгалаа дуустал ард түмэн, өөрийн Зөвлөлт эх орон, Зөвлөлт засгийн газартаа үнэнч байхаа тангараглая.

Би Зөвлөлт засгийн газрын тушаалаар Зэвсэгт хүчний байлдагч болохынхоо хувьд Зөвлөлт социалист бүгд найрамдах улс буюу өөрийн эх орноо амь нас, дусал цусаа үл хайрлан дайсныг бүрэн ялахын төлөө эр зоригтой, чадварлаг, нэр төртэйгээр хамгаалахаа тангараглая.

Хэрэв би энэхүү тангарагаасаа няцвал зөвлөлтийн хуулийн дагуу хатуу шийтгүүлж, хөдөлмөрчид олон түмэнд жигшигдэх болно.

5. Военная присяга Российской армии (с 1993 года)

Я, (фамилия, имя, отчество), торжественно присягаю на верность своей Родине - Российской Федерации.

Клянусь свято соблюдать ее Конституцию и законы, строго выполнять требования воинских уставов, приказы командиров и начальников.

Клянусь достойно выполнять воинский долг, мужественно защищать свободу, независимость и конституционный строй России, народ и Отечество.

Утверждена законом Российской Федерации "О воинской обязанности и военной службе" от 11 февраля 1993 г.

ОХУ-ын армийн цэргийн тангараг /1993 он/

Би /овог нэр/ миний бие ОХУ болох өөрийн эх орондоо үнэнч байхаа ёслол төгөлдөр тангараглая.

Үндсэн хууль болон хууль ёсыг дээдлэн сахиж, цэргийн үүрэг болон цэргийн дарга захирагч нарынхаа тушаалыг хатуу чанд биелүүлэхээ тангараглая.

Цэргийн үүргээ нэр төртэй биелүүлж, Орос орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, үндсэн хуульт тогтолцоо болон эх орон, ард түмнээ эр зоригтойгоор хамгаалахаа тангараглая.

Хэрэв би энэхүү тангарагаасаа няцвал зөвлөлтийн хуулийн дагуу хатуу шийтгүүлж, хөдөлмөрчид олон түмэнд жигшигдэх болно.

1993 оны 02-р сарын 11 өдөр "Цэргийн үүрэг ба цэргийн албаны тухай" ОХУ-ын хуулиар батлав.

ЗХУ-ын 1970-1990 онуудад мөрдөж байсан цэргийн тангарагт "...цэргийн болон улсын нууцыг чанд хадгалж, цэргийн дарга, захирагч, комиссарын тушаал зарлигийг биелүүлэхээ ёслол төгөлдөр тангараглая. ...Хэрэв би энэхүү тангарагаасаа няцвал зөвлөлтийн хуулийн дагуу хатуу шийтгүүлж, хөдөлмөрчид олон түмэнд жигшигдэх болно" гэсэн утга санааг БНМАУ-ын 1970-1990 онуудад мөрдөгдөж байсан цэргийн тангарагт "...цэргийн бүх дүрэм, дарга захирал нарыг тушаалыг үг дуугүй биелүүлэхээ ёслол төгөлдөр тангараглана. ...Миний бие санаатайгаар энэ тангарагаа няцвал Монголын хөдөлмөрчин ард түмэнд үүрд жигшигдэн төрийн хуулийн хамгийн дээд хэмжээгээр цээрлэгдэг" хэмээн шууд хуулбарлан авчээ.

Үүнээс үзвэл цэргийн дарга захирагч, комиссар нарын тушаалыг үг дуугүй биелүүлэхийг эс зөвшөөрвөл төрийн хуулийн хамгийн дээд хэмжээгээр цээрлэл хүлээлгэх сэтгэлгээгээр тангарагийн бус харилцааг хөгжүүлж ирсэн.

Социализмын задралын төгсгөл үеийн 1970-1990 онуудад хугацаат цэргийн албанд татагдсан монгол улсын иргэд иргэнийхээ үүргийг ёс төртэй биелүүлж байсан бөгөөд нийт цэрэг армийн бие бүрэлдэхүүн үзэл суртал, хүйтэн дайны үеийн нийгмийн сэтгэл зүйг хамгийн ихээр тодорхойлж байсан.

Тангарагийн бус харилцаа буюу хугацаат цэргийн албан дахь оны ялгаанд суурилсан хатуу дэглэм нь үндсэн хуулинд заагдсан эх орноо хамгаалах хүндтэй үүргийг гажуудуулж, тухайн үеийн цэрэг эрсийг сэтгэл зүй болон ёс суртахууны хувьд доройтуулж байсан нь араасаа олон муу үр дагаврыг авчирсан юм. Тухайлбал, хугацаат 3 жилд “хал” цэрэг /гурав дахь оны цэрэг/, “асман” цэрэг /хоёрдугаар оны цэрэг/, шинэ цэрэг /нэгдүгээр оны цэрэг/ гэж ангилал тогтоон оны ялгааг бий болгон гурав дахь оны цэргүүд доод хоёр оны цэргүүдээ залхаан цэрлүүлж дэглэдэг үзэгдэл батлан хамгаалах салбарт ноёрхож байсан.

Үүнийг БНМАУ-ын батлан хамгаалахын удирдлага мэддэг атлаа нуун дарагдуулж анги, батальон, дивизийн офицерүүд ч хууль бус үйл ажиллагаанд татагдан оролцох болсон юм. Тиймээс бие бүрэлдэхүүний удирдлагаас албан тушаалдаа тэнцэхгүй, шүүхээр шийтгүүлсэн, ёс суртахууны доголдолтой олон албан хаагчид байсан. Хугацаат цэргийн албан хаагчид хатуу дэглэмийн он жилүүдэд зодуулах, бие эрхтний гэмтэл авах, амиа алдах, оргох, өс хонзон авч байлдааны зэвсэг хэрэглэх, сэтгэл зүйн дарамтанд автах зэрэг ноцтой хууль бус үйлдлүүд газар авсан байлаа.

Гэвч хугацаат цэргийн албан дахь хууль бус үйлдлүүд нь дан ганц цэрэг дайчдад биш тэднийг удирдаж байсан офицер, ахлагч нийт бие бүрэлдэхүүний дунд он удаан жил оршин тогтнож байсан нь түүх бичлэгт огт хөндөгдөөгүй юм. Учир нь батлан хамгаалах үйл ажиллагааны шинэчлэл удаашралтай явагдаж байгаа болон тухайн салбарын түүхийг судлах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судалгааны ажлын хүрээнд Монголын түүхчид хамааруулан орхисон байна. 1990-ээд оны эхний байдлаар цэргийн эрдэмтдийн 22% нь цэргийн хүмүүс, 18% нь техникийн, 14% философийн, 20% түүхийн, 10% нь хууль зүйн, 15% нь анагаахын, 5% нь сурган хүмүүжүүлэх ухаанаар эрдмийн зэрэг хамгаалсан ч эрдэм шинжилгээний бүтээлүүдэд тангарагийн бус харилцаатай холбогдолтой шинжлэх ухааны эргэлтэнд орсон баримт бараг байхгүй байна.

Улс орны аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс батлан хамгаалах хүч чадлаа бэхжүүлж зэвсэгт хүчнийг дахин сэргээж өргөтгөн зохион байгуулах зэвсэг байлдааны техникээр хангах, цэргийн боловсон хүчнийг яаравчлан бэлтгэх, бие бүрэлдэхүүний бэлтгэлийг дээшлүүлэх зэрэг цэргийн байгууллагын томоохон асуудлыг БНМАУ хэрэг дээрээ бие даан шийдвэрлэх бололцоогүй байлаа.

1950-иад оноос 1990 оныг хүртэлх үеийг Ардын армийн хөгжлийн шинэ үе гэж үздэг ба 1966 оноос ЗХУ-д цэргийн боловсон хүчнээ эрчимтэй бэлтгэж эхэлсэн. 1960-аад оны дунд үеэс эхлэн хүйтэн дайн улам бүр хүчээ авч, олон улсын байдал хүндэрч, ЗХУ ба БНХАУ хоёр улсын үзэл суртал, улс төрийн зөрчил ширүүсч байсны улмаас Ази тив, Монгол орны гадаад орчин нарийн төвөгтэй болж байжээ. Зөвлөлтийн цэрэг Монголын нутагт байрлаж байсан хугацаанд “Хэрлэн 73”, “Говь 77”, “Найрамдал 79” зэрэг хээрийн сургуулийг 5 удаа зохион байгуулжээ. Иймээс улсыг батлан хамгаалахаар арга хэмжээ авч ЗХУ-тай цэргийн хамтын ажиллагаагаа хөгжүүлж түүнтэй хамт тангарагийн бус харилцаа ч хөгжиж эхэлсэн.

1970-1990 онуудад БНМАУ-ын хугацаат цэргийн албан хаагч, бие бүрэлдэхүүний дунд тангарагийн бус харилцаа дараах байдлаар илэрч байсан. Үүнд:

1	Хугацаат цэргийн албан хаагчдын дотоод	• Хоололт • Хувцаслалтын байдал
---	--	--

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

	амьдрал	• Хүмүүжил, сургалтын үйл ажиллагаа • Дэглэх шалтгаан • Байршил • Цаг, хугацаа • Биеийн жин
	Офицер, албан хаагчдын харьцаа	• Хоорондын харьцаа • 3 оноор ялгавартай харьцаж буй байдал • Хугацаат цэргийн албанд дэглэлтийг даамжруулах нөхцөл бүрдүүлэх • Хугацаат цэргийн албанд дэглэлтийг нуун дарагдуулах
2	Хууль бус үйлдлийн хэлбэрүүд	• Цэргийн дүрэм гажуудуулан дэглэх • Бие эрхтэнд нь гэмтэл учруулах
3	Үр дагавар	• Бие эрхтэн гэмтэх • Амь насаа алдах • Хугацаат цэргийн албыг олон нийт дунд нэр хүндгүй болгох • Сэтгэл санааны хямралд орох • Оргох • Амиа хорлох • Өс авах • Эрүүл мэндээрээ хохирох • Сэтгэл зүйн дарамтанд орох
5	Хэллэгүүд	• Гоожуур, каш гэх мэт

1970-1990 онуудад офицерийн хэрэгцээг хангахын тулд түр дамжааг зохион байгуулах, шууд офицер болгох зэрэг яаралтай авсан арга хэмжээ зохих ач холбогдлоо өгсөн хэдий ч сонголтыг тэр болгон сайн хийж байгаагүйгээс офицерийн нэр төрийг хадгалж чадахгүй зарим нэг хүмүүс армийн жагсаалд орж офицерийн бүрэлдэхүүний чанар, цэргийн сургалт хүмүүжлийн ажлын үр ашиг, сахилаг зохин байгуулалтанд зарим нэг сөрөг нөлөө үзүүлж байсан. Тангарагийн бус харилцаанд оролцсон цэргийн бие бүрэлдэхүүнээс ...1976-1980 онд 121 хүн офицерийн албан тушаалд тэнцэхгүй шалтгаанаар халагдаж байв. 1980-1982 онд 91 офицер албан тушаал буурч 95 офицер шүүхээр шийтгүүлсэн байна. /Монгол цэргийн товчоон. УБ., 1996, II боть. 440 тал/

Түүхийн шинжлэх ухаанд цэрэг иргэний түүхийг судалдаг уламжлалыг хадгалан хугацаат цэргийн албан дахь хууль бус үйлдлүүдийг тусгайлан судлах зайлшгүй шаардлага тавигдаж байна. Энэхүү судалгааны асуудал нь зөвхөн цэргийн түүхтэй салшгүй холбоотой бус сурвалж судлал, намтар судлал, түүхэн газар зүй, түүхэн хүн амзүй, түүхэн социологи зэрэг олон хавсрага ухаануудын уулзвар зааг дээр оршиж байгаа тул судалгааны олон аргуудыг хослуулан судлах нь ач холбогдолтой юм.

Резюме. В настоящей статье автором выдвинута предложение о детальном изучении о неуставных отношениях в рядах монгольской армии в период с 1970 по 1990 гг. Изучение данной проблемы дает возможность понять солдатскую жизнь и рассмотреть социально-политическую обстановку этого времени на более широком аспекте.

Ашигласан ном:

1. Ард нийтээр цэргийн алба хаах тухай хууль. 1951
2. "Ардын эрх" сонин 1995 №193

3. БНМАУ-ын зэвсэгт хүчин УБ., 1981
4. БНМАУ-ын бүх нийтийн цэргийн үүргийн тухай хууль. 1988
5. БНМАУ-ын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. УБ., 1994
6. Монголын ардын арми 50 жил. УБ., 1971
7. Монголын ардын арми 60 жил. УБ., 1981
8. Монгол цэргийн түүхийн товчоон. УБ., 1996.
9. Монгол зөвлөлтийн харилцаа. УБ., 1981
10. П.Сүндэв. Монгол улсын хилчний тайлбар толь. УБ., 2003
11. Ю.Цэдэнбал. Би тангарагтаа үнэнч байсан. УБ., 1996